

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН
2024 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН ХЭРЭГЖИЛТ**

2024 оны 10 дугаар сарын 07

Улаанбаатар хот

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар		Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Биелэлт	Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	6	7
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл						
1	1	ХҮИИ.2.7.Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх, бэлтгэл хангах арга хэмжээ авах, үйл ажиллагааг тусгайлан зохицуулсан хөтөлбөр боловсруулж батлуулан ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт;	2022 оны 5 дугаар сарын 4-ний өдөр 27 дугаар тэмдэглэл 2022-05-04 Дугаар 2022_27	“Монголд зочлох жил”-ийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн А/314 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус байгууллагаас Виз, зөвшөөрлийн газрын дарга ажиллаж, Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн “Журам батлах тухай” 142 дугаар тогтоолоор "Хил орчмын нутаг дэвсгэрийн аялал жуулчлалын үйл ажиллагааг зохион байгуулах, аюулгүй байдлыг хангах журам"-ыг баталсан. Аялал жуулчлалын тухай хуулийн 18.1 дэх хэсэгт заасны дагуу хоёр улсын хоорондын иж бүрэн стратегийн түншлэлийг бэхжүүлэх зорилгоор “Аялал жуулчлалын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр талууд харилцан гарын үсэг зурж, Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан хэлэлцээр байгуулснаар хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх эрх зүйн үндсийг тавьсан. Уг хэлэлцээрээр Монгол Улсын хил орчмын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын зорилгоор зорчих		100

1	2	3	4	5	6	7
				<p>БНХАУ-ын бүлэг жуулчид хил нэвтрэх нөхцөлд 1 жилийн хүчинтэй хугацаатай олон удаагийн “орох, гарах БНХАУ-ын зорчих үнэмлэх” эзэмшигч бүлэг жуулчдын ахлагч эсхүл хөтөч-орчуулагч нь визгүйгээр Монгол Улсад нэвтрэх ба түүнийг дагалдан Монгол Улсад зорчих 3 сарын хүчинтэй хугацаатай нэг удаагийн “хил орчмын аялал жуулчлалын зориулалт бүхий орох, гарах БНХАУ-ын зорчих үнэмлэх”-тэй БНХАУ-ын бүлэг жуулчид “Нэрсийн жагсаалт”-аар Монгол Улсад нэвтэрч болохоор тохиров. Одоогийн байдлаар дээрх 1 жилийн хугацаатай, олон удаагийн болон 3 сарын хүчинтэй хугацаатай, нэг удаагийн, хил орчмын аялал жуулчлалын зориулалт бүхий зорчих үнэмлэхийн загвартай тус тус танилцаад байна. Хилийн боомтод виз олгох үйлчилгээг түргэн шуурхай зохион байгуулах зорилгоор “e-form.mn” программ хангамжийг тус байгууллагаас шинээр хөгжүүлэн үйл ажиллагаанд ашиглаж байна.</p>		
Хэсгийн дундаж: 100 хувь						
Нийт дундаж: 100 хувь						

--oo0oo--